



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРОО

МӨНГӨ, ЗЭЭЛ, ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ, 2018 ОН

Улаанбаатар хот
2019 он

Танилцуулгыг хянасан:

А.Ариунзаяа	ҮСХ-ны дарга
Ч.Баянчимэг	ҮСХ-ны дэд дарга
Э.Эрдэнэсан	ҮСХ-ны ЭЗСГ-ын дарга
М.Оюунжаргал	ҮСХ-ны ЭЗСГ-ын ахлах статистикч

Танилцуулгыг боловсруулсан:

А.Мөнхцэцэг	ҮСХ-ны ЭЗСГ-ын статистикч
Д.Ганзул	ҮСХ-ны ЭЗСГ-ын статистикч

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44
Засгийн газрын III байр
Утас: (976-11)-326414, 1900-1212
Факс: (976-11)-324518
Цахим хуудас: <http://nso.mn>, www.1212.mn
И-мэйл: information@nso.mn

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	3
ОРШИЛ.....	4
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ.....	5
I. МӨНГӨ.....	9
I.1 Мөнгөний нийлүүлэлт (M2).....	11
I.1.1 Бага мөнгө (M1).....	14
I.1.2 Бараг мөнгө.....	14
I.2 Нөөц мөнгө (MO).....	16
I.3 Мөнгөний үржүүлэгч	18
I.4 Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө	18
I.5 Валютын ханш, долларжилт.....	19
I.6 Салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр, мөнгөжүүлэлт.....	21
II. ЗЭЭЛ, ЗЭЭЛИЙН ХҮҮ.....	22
II.1 Зээл.....	23
II.2 Зээлийн хүү.....	23
II.3 Зээлийн өрийн үлдэгдэл.....	24
II.3.1 Зээлийн өрийн үлдэгдэл, салбараар.....	25
II.3.2 Иргэдийн зээлийн өрийн үлдэгдэл.....	28
III. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ.....	30
IV.1 Даатгал.....	34
IV.2 Банк бус санхүүгийн байгууллага.....	34
IV.3 Хадгаламж, зээлийн хоршоо.....	35
ДҮГНЭЛТ.....	36

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Мөнгөний нийлүүлэлт, жил бүрийн эцэст
- Хүснэгт 2. Нийт хадгаламж, жил бүрийн эцэст
- Хүснэгт 3. Мөнгөний үржүүлэгч
- Хүснэгт 4. Төгрөгийн гадаад валюттай харьцах төв банкны нэрлэсэн ханш, төгрөгөөр
- Хүснэгт 5. Мөнгө, зээлийн зарим үзүүлэлт, хувиар
- Хүснэгт 6. Олгосон болон төлөгдсөн зээл, улирал бүрээр
- Хүснэгт 7. Зээлийн өрийн үлдэгдлийн төрөл, жилийн эцэст
- Хүснэгт 8. Зээлийн өрийн үлдэгдэл, салбараар, жилийн эцэст
- Хүснэгт 9. Хувийн салбарын зээлийн өрийн үлдэгдэл, төрлөөр, жилийн эцэст
- Хүснэгт 10. Иргэдийн зээлийн өрийн үлдэгдэл, төрлөөр, жилийн эцэст
- Хүснэгт 11. Үнэт цаасны зах зээлийн үндсэн үзүүлэлт
- Хүснэгт 12. Хувьцааны арилжааны үзүүлэлт
- Хүснэгт 13. Засгийн газрын бондын арилжаа
- Хүснэгт 14. Даатгалын байгууллагын үндсэн үзүүлэлт
- Хүснэгт 15. Банк бус санхүүгийн байгууллагын үндсэн үзүүлэлт

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Мөнгөний нийлүүлэлтийн сарын дундаж өөрчлөлт, хувиар
- Зураг 2. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц, хувиар
- Зураг 3. Инфляци, мөнгөний нийлүүлэлтийн цэвэр өөрчлөлт, хувиар
- Зураг 4. Мөнгөний нийлүүлэлт (M2), бага мөнгө (M1) болон бараг мөнгөний цэвэр өөрчлөлт, сар бүрийн эцэст, хувиар
- Зураг 5. Бага мөнгөний (M1)-ний бүтэц, хувиар
- Зураг 6. Бараг мөнгөний бүтэц, хувиар
- Зураг 7. Нөөц мөнгө (M0)-ний засварласан улирлын индекс
- Зураг 8. Нөөц мөнгө (M0)-ний бүтэц, хувиар
- Зураг 9. Банкнаас гадуурх мөнгө (M0)-ний засварласан улирлын индекс
- Зураг 10. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний өөрчлөлт, хувиар, сараар
- Зураг 11. Төгрөгийн гадаад валюттай харьцах төв банкны нэрлэсэн дундаж ханшны өөрчлөлт, сар бүрийн эцэст, хувиар
- Зураг 12. Долларжилт, хувиар
- Зураг 13. Мөнгө, зээлийн зарим үзүүлэлт, хувиар
- Зураг 14. Зээлийн жилийн хүү, сарын эцэст, хувиар
- Зураг 15. Зээлийн өрийн үлдэгдэл, жилийн цэвэр өөрчлөлт, хувиар
- Зураг 16. Зээлийн өрийн үлдэгдэл, салбараар, хувиар
- Зураг 17. Иргэдийн зээлийн өрийн үлдэгдэл, төрлөөр, жилийн цэвэр өөрчлөлт, хувиар, 2018
- Зураг 18. Хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, жилийн эцэст, тэрбум төг
- Зураг 19. ТОП-20 дундаж индекс, жил бүрийн дундаж
- Зураг 20. Хадгаламж, зээлийн хоршоодын зарим үзүүлэлт

ОРШИЛ

Дэлхийн улс орнууд мөнгө, зээлийн статистикийн судалгаагаар мөнгөний бүтэц, динамик өөрчлөлт, мөнгөний эргэлт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, мөнгөний худалдан авах чадварын өөрчлөлт, зээлийн хэмжээ, бүтэц, хадгаламж, зээлийн хүүгийн түвшин зэргийг харилцан уялдаатай судалж байна. Улс орнуудад мөнгөний бүтэц харилцан адилгүй шатлалтай байдаг хэдий ч Олон улсын валютын сангийн зөвлөмжийг голлон баримталдаг.

Монгол Улс 1991 оноос Төв банк, арилжааны банк гэсэн хоёр шатлалтай банкны тогтолцоонд шилжиж, арилжааны банкны үйл ажиллагааг Монгол Улсын “Банкны тухай” хуулиар зохицуулж байна. Монголбанк арилжааны банкуудын тайлан тэнцлийн мэдээллийг нэгтгэн мөнгөний нийлүүлэлт, мөнгөний тойм, банкуудын нэгдсэн тайлан, олгосон зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламж, зээлийн хүү, гадаад валютын зах зээлийн ханшийн талаарх статистикийн мэдээг сар бүр бэлтгэдэг бөгөөд мөнгө, зээлийн бодлогын үр дүнгийн жилийн тайланг хэвлүүлж байна.

Олон улсын валютын сангаас 2000 онд эрхлэн гаргасан “Мөнгө, санхүүгийн статистикийн гарын авлага”-д тулгуурлан “Мөнгө, зээл, үнэт цаасны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг ҮСХ-ны даргын 2010 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 1/526 тушаалаар батлуулан мөрдөж байна. Тус аргачлалын дагуу мөнгө, зээлийн статистикийн мэдээллийг Монголбанкнаас, үнэт цаасны статистик мэдээллийг Хөрөнгийн биржээс, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны статистик мэдээллийг Санхүүгийн зохицуулах хорооноос авч, сар, улирал, жилийн бюллетень, эмхтгэлд тусган тархааж байна.

Энэхүү танилцуулгад мөнгө зээл, үнэт цаасны ойлголт, тодорхойлолтыг оруулсан. Мөнгөний үзүүлэлт, хадгаламж, зээл, зээлийн хүүгийн өөрчлөлтийг судлаж, мөнгөний эргэлтийн хурд, мөнгөний үржүүлэгч, мөнгөжүүлэлт, валютын ханшны талаар, долларжилт буюу өөр орны валютыг хэр зэрэг ашиглаж байгааг, үнэт цаасны зах зээл, санхүүгийн бусад салбар буюу даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооны өнөөгийн байдлын талаар авч үзлээ.

ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ

Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээлийн статистикт дараах ойлголт, тодорхойлолтыг ашигладаг. Үүнд:

Ойлголт	Тодорхойлолт
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	Банкнаас гадуурх мөнгө болон банкны касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.
Бага мөнгө /M1/	Банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.
Банкнаас гадуурх мөнгө	Төв банкнаас гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгөнөөс банкуудын эзэмшиж буй цаасан болон зоосон мөнгийг хасна.
Төгрөгийн харилцах дансан дахь мөнгө	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.
Бараг мөнгө	Төгрөг болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.
Төгрөг болон валютын хадгаламж	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.
Валютын харилцах	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тодорхойлно.
Цэвэршүүлсэн алтны харилцах	Мөнгөний нийлүүлэлтэд үлдэгдлээрээ хамрагдах бөгөөд бусад үнэт металлын харилцах дансны үлдэгдлийг энд хамруулахгүй.
Хадгаламжийн сертификат	Арилжааны банкнаас гаргасан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж буй хадгаламжийн сертификатаар тооцно.
Мөнгөний нийлүүлэлт /M2/	Банкнаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэр буюу бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно.
Хэвийн зээл	Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.
Хугацаа хэтэрсэн зээл	Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно.
Чанаргүй зээл	Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно.
Гадаад валютын албан нөөц	Монголбанкны эзэмшилд байгаа, захиран зарцуулахад бэлэн, чөлөөтэй хөрвөдөг гадаад валютыг ойлгоно.
Гадаад валют	Гадаадын мөнгөн тэмдэгт, улс хоорондын худалдаа эдийн засаг, санхүүгийн харилцааны төлбөрт хэрэглэж байгаа гадаад орны мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдэж, түүгээр төлөгдөх үнэт цаас, төлбөрийн бусад хэрэгслийг;
Мөнгөжүүлэлт	Эдийн засагт эргэж буй нийт мөнгийг хэлнэ. Өөрөөр хэлбэл мөнгөний нийлүүлэлтийн ДНБ-д эзлэх хувь (M2/ДНБ) юм.
Мөнгөний эргэлтийн хурд	Эдийн засагт нийлүүлэгдэж буй мөнгө хэдэн удаа эргэлтэнд орж байгааг илэрхийлдэг үзүүлэлт бөгөөд дараахь томъёогоор илэрхийлэгдэнэ. Үүнд: $V = \frac{P \cdot Y}{M2} = \frac{ДНБ_{оны}}{M2}$

Ойлголт	Тодорхойлолт
	V- Мөнгөний эргэлтийн хурд P- Үнэ Y- Үйлдвэрлэлт ДНБ-Дотоодын нийт бүтээгдэхүүн, оны үнээр
Мөнгөний үржүүлэгч	Нөөц мөнгийг хэд дахин өсгөж нийт мөнгө болгож байгааг үзүүлэх бөгөөд дараах томъёогоор илэрхийлэгдэнэ. Үүнд: $mm = \frac{M2}{M0}$ mm-Мөнгөний үржүүлэгч M2-Нийт мөнгө M0-Нөөц мөнгө
Валютын ханш	Тухайн улсын валютыг өөр нэгэн улсын валютаар илэрхийлсэн дүн.
Долларжилт	Ямар нэг орны иргэд үндэсний мөнгөн тэмдэгтэйгээ зэрэг буюу түүний оронд өөр орны валютыг өргөн ашиглаж байгаа үзэгдлийг хэлнэ.Долларжилтийг активийн долларжилт (нийт мөнгөнд валютын хадгаламж, харилцахын эзлэх хувь), өрийн долларжилт (нийт зээлд валютын зээлийн эзлэх хувь) гэж 2 төрөл болгон авч үздэг. Активын долларжилт 20 хувиас бага бол бага долларжилттэй, 20-70 хувь бол дунд зэргийн долларжилттэй, 70-аас дээш бол өндөр долларжилттэй гэж ангилдаг.
Үнэт цаас	Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан, эсхүл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг /опцион/, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол Улсын “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг;
Өрийн бичиг /бонд/	Тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаасыг;
Хувьцаа	Компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг;
Брокерийн ажиллагаа	үйл Үнэт цаасны зах зээл дээр бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах ажиллагааг;
Дилерийн ажиллагаа	үйл Үнэт цаасны зах зээл дээр ашиг олох зорилгоор үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авах, худалдах ажиллагааг;
Хэлцэл	Үнэт цаасыг худалдах захиалгын үнийн саналыг худалдан авах иргэд, аж ахуйн нэгж, байгууллага зөвшөөрснөөр үнэт цаас арилжаалах үйл ажиллагааг;
Бүртгэлтэй компанийн тоо	Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, хувьцааны арилжааг идэвхитэй хийдэг хувьцаат компанийн тоог ойлгоно;
Зах зээлийн үнэлгээг	Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн нийтэд гаргасан үнэт цаасны тоо, тухайн өдрийн үнэт цаасны арилжааны хаалтын ханшны үржвэрээр тодорхойлно.

Ойлголт	Тодорхойлолт
ТОП -20 индекс	<p>Үнэт цаасны үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлэх бөгөөд Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны өсөлт, бууралтаар үнэт цаасны зах зээлийн ерөнхий чиг хандлагыг тодорхойлно. Индексийг дараах томъёогоор тооцно. Үүнд:</p> $I = \frac{P}{C} \cdot 100$ <p>I - Тухайн өдрийн индекс P - Тухайн өдрийн зах зээлийн үнэлгээ C - Зах зээлийн суурь үнэлгээ</p>
Санхүүгийн салбар бусад	Монгол Улсын Төв банк болон арилжааны банкнаас бусад санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага (даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ гэх мэт)-ыг ойлгоно.
Санхүүгийн зохицуулах хороо	Даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоодын тайлан тэнцлийн мэдээллийг нэгтгэн үйл ажиллагааны нэгдсэн тайлан, статистикийн мэдээллийг улирал бүр гаргаж байна.
Даатгалын ажиллагаа үйл	Даатгалын гэрээний дагуу даатгагч нь хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагаа юм.
Даатгалын хураамж Даатгалын нөхөн төлбөр	Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг ойлгоно. Гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө юм.
Даатгалын нөөцийн сангийн өөрчлөлт	Даатгагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх зорилгоор даатгалын нөөцийн сан бүрдүүлнэ. Энэхүү нөөцийн сангийн хэмжээ, бүрдүүлэх болон хөрөнгө оруулалтад байршуулах нөхцөлийг даатгалын багц дүрмээр тогтооно. Даатгалын нөөцийн сангийн өөрчлөлтийг даатгалын байгууллагуудын нөөцийн сангийн оны эхний болон оны эцсийн зөрүүгээр тодорхойлно.
Банк бус санхүүгийн үйл ажиллагаа	Зээл олгох, факторингийн үйлчилгээ (зээлдэгчийн зүгээс зээлдүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах болон шилжүүлэх, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүрэн хариуцах үйл ажиллагаа), санхүүгийн түрээсийн үйлчилгээ (түрээслүүлэгч нь түрээслэгчийн захиалсан буюу сонгосон эд хөрөнгийг өөрөө үйлдвэрлэх, эсхүл худалдагч буюу нийлүүлэгчээс өөрийн нэр дээр худалдан авах замаар түрээслэгчид тодорхой нөхцөл, хугацаа, төлбөртэйгээр түрээслэх үйл ажиллагаа), төлбөрийн баталгаа болон төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээ, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, гадаад валютын арилжаа, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх зэрэг үйл ажиллагааг ойлгоно.
Санхүүгийн орлогод	Бүх төрлийн хүүгийн орлого, санхүүгийн түрээсийн орлого, факторингийн үйлчилгээний хүүгийн орлого, гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, үнэт цаасны үнэлгээний


Ойлголт	Тодорхойлолт
	тэгшитгэлийн орлого, гадаад валют болон үнэт цаасны арилжааны орлого, итгэлцлийн үйл ажиллагаанаас орох орлого, мөнгөн гуйвуулгын орлого, санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого, харилцах дансны хүүгийн орлого, банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого болон үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлогыг хамруулна.
Санхүүгийн зардалд	Бүх төрлийн хүүгийн зардал, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаатай холбоотой гарсан зардлууд, факторинг, итгэлцлийн үйл ажиллагаатай холбоотой гарсан зардлууд, гадаад валют, үнэт цаасны арилжааны зардлууд болон тэгшитгэлийн зардлууд, шимтгэлийн зардал, хүүгийн зардлын буцаалт оруулна.
Санхүүгийн цэвэр ашгийг	Санхүүгийн орлогоос санхүүгийн зардал болон болзошгүй эрсдэлийн зардлыг хасаж тооцно.
Болзошгүй эрсдэлийн зардал	Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны явцад гарсан эрсдэлд зарцуулсан зардал юм. Энэхүү зардалд үнэт цаасны арилжаа, зээл, санхүүгийн түрээс, факторингийн үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгө, авлагын эрсдэлийн зардлыг хамруулна.
Хоршоо	Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээд юм.

МӨНГӨ, ЗЭЭЛ, ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ 2018 ОНД



Мөнгөний нийлүүлэлт

₮ 19.5 их наяд төгрөг



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ



Хувьцааны арилжаа

666.8
сая ширхэг

210.0 тэрбум төгрөг



59



Брокер, дилерийн компанийн тоо

ТОП-20 индекс

НЭГЖ

20 076.50 дундаж

Валютын ханш, жилийн дундаж



2017



2018



Валютын ханш, төгрөгөөр, жилийн дундаж



I.1 МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ (M2)


Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт (M2) 2018 оны жилийн эцэст 19.5 их наяд төгрөг болж, 2014 оноос 8.8 их наяд төгрөг буюу 83.1 хувиар, 2015 оноос 9.4 их наяд төгрөг буюу 93.8 хувиар, 2016 оноос 7.3 их наяд төгрөг буюу 60.2 хувиар, 2017 оноос 3.6 их наяд төгрөг буюу 22.8 хувиар тус тус өсжээ. Мөнгөний нийлүүлэлт өмнөх оноос өсөхөд бараг мөнгө 2.4 их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн (Хүснэгт 1).

ХҮСНЭГТ 1. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ, жилийн бүрийн эцэст

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Мөнгөний нийлүүлэлт (M2), тэрбум төг	10 634.3	10 049.0	12 158.5	15 861.2	19 474.8
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	12.5	-5.5	21	30.5	22.8
Бараг мөнгө, тэрбум төг	8 817.9	8 363.5	10 010.8	13 035.2	15 443.5
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	19.8	-5.2	19.7	30.2	18.5
Нийт хадгаламж, тэрбум төг	7 378.9	7 381.8	8 579.6	11 153.9	13 175.5
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	15.6	0.04	16.2	30	18.1
Төгрөгийн хадгаламж, тэрбум төг	5 410.3	5 434.0	5 789.9	8 622.0	10 156.0
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	10.2	0.4	6.5	48.9	17.8
Валютын хадгаламж, тэрбум төг	1 968.6	1 947.8	2 789.7	2 531.9	3 019.5
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	33.5	-1.1	43.2	-9.2	19.3
Валютын харилцах, тэрбум төг	1 439.1	981.7	1 431.2	1 881.3	2 268.0
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	47.7	-31.8	45.8	31.4	20.6
Бага мөнгө (M1), тэрбум төг	1 816.4	1 685.4	2 147.7	2 826.0	4 031.0
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	-13.2	-7.2	27.4	31.6	42.6
Төгрөгийн харилцах, тэрбум төг	1 317.1	1 226.7	1 585.0	2 214.3	3 360.5
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	-12.8	-6.9	29.2	39.7	51.8
Банкнаас гадуурх мөнгө, тэрбум төг	499.3	458.7	562.9	611.7	670.5
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	-14.2	-8.1	22.7	8.7	9.6

Мөнгөний нийлүүлэлт 2014 онд сард дунджаар 1.0 хувь, 2016 онд 1.6 хувь, 2017 онд 2.3 хувь, 2018 онд 1.7 хувиар өсөж, харин 2015 онд сард дунджаар 0.5 хувиар буурсан байна (Зураг 1).

ЗУРАГ 1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН САРЫН ДУНДАЖ ӨӨРЧЛӨЛТ, хувиар



Мөнгөний нийлүүлэлтийн 15443.8 тэрбум төгрөг буюу 79.3 хувийг бараг мөнгө, 4031.0 тэрбум төгрөг буюу 20.7 хувийг бага мөнгө (M1) эзэлж байна (Зураг 2). Өмнөх онтой харьцуулахад мөнгөний нийлүүлэлтэд гадаад валютын харилцахын эзлэх хувь 11.7 болж 0.2 пунктээр, валютын хадгаламжийн эзлэх хувь 15.5 болж 0.5 пунктээр, банкнаас гадуурх мөнгөний эзлэх хувь 3.4 болж 0.4 пунктээр, төгрөгийн хадгаламжийн эзлэх хувь 52.2 болж 2.2 пунктээр буурч, харин төгрөгийн харилцахын эзлэх хувь 17.3 буюу 3.3 пунктээр өссөн байна.

ЗУРАГ 2. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН БҮТЭЦ, хувиар



Мөнгөний бодлогын талаар төрөөс 2018-2020 онд баримтлах үндсэн чиглэлд инфляцийг жилийн 8.0 хувь байх зорилт тавьсан ба 2018 онд инфляци 8.1 хувь болов.

ЗУРАГ 3. ИНФЛЯЦИ, МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ЦЭВЭР ӨӨРЧЛӨЛТ, хувиар




Мөнгөний нийлүүлэлт (M2) 2017 онд өмнөх оноос 3702.2 тэрбум төгрөгөөр буюу 30.5 хувь, 2018 онд өмнөх оноос 3613.6 тэрбум төгрөгөөр буюу 22.8 хувиар өсөж, өсөлтийн хувь 7.7 пунктээр буурсан байна (Зураг 3).

Бага мөнгө (M1) 2017 онд өмнөх оноос 678.3 тэрбум төгрөгөөр буюу 31.6 хувь өсөж байсан бол 2018 онд өмнөх оноос 1205.0 тэрбум төгрөг буюу 42.6 хувь болж, өмнөх оноос 11.1 пунктээр өссөн байна.

Бараг мөнгө 2017 онд өмнөх оноос 3024.0 тэрбум төгрөгөөр буюу 30.2 хувиар өсөж байсан бол 2018 онд өмнөх оноос 2408.6 тэрбум төгрөгөөр буюу 18.5 хувь өсөж, өмнөх оноос 11.7 пунктээр буурчээ (Зураг 4).

ЗУРАГ 4. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ (M2), БАГА МӨНГӨ (M1) БОЛОН БАРАГ МӨНГӨНИЙ ЦЭВЭР ӨӨРЧЛӨЛТ, сар бүрийн эцэст, хувиар, (өмнөх оны мөн үе=100)




I.1.1 Бага мөнгө (M1)

Бага мөнгө (M1) 2018 оны эцэст 4.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.2 их наяд төгрөгөөр буюу 42.6 хувиар өссөн бөгөөд төгрөгийн харилцах 1.1 их наяд төгрөг буюу 51.8 хувь, банкнаас гадуурх мөнгө 58.8 тэрбум төг буюу 9.6 хувиар өсжээ. (Хүснэгт 1).

Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийн цар хүрээ өргөжихийн хэрээр бага мөнгөнд банкнаас гадуурх мөнгөний эзлэх хувийн жин буурч, төгрөгийн харилцах голлох хувийг эзлэх боллоо. Тухайлбал, төгрөгийн харилцахын бага мөнгөнд эзлэх хувийн жин 2017 онд 78.4 хувь байсан бол 2018 онд 83.4 хувийг эзлэх болж, өмнөх оноос 5 пунктээр өссөн байна. Харин банкнаас гадуурх мөнгөний бага мөнгөнд эзлэх хувийн жин 2017 онд 21.6 хувь байсан бол 2018 онд 16.6 хувь болж, өмнөх оноос 5.0 пунктээр буурчээ (Зураг 5).

ЗУРАГ 5. БАГА МӨНГӨ (M1)-НИЙ БҮТЭЦ, хувиар




I.1.2 Бараг мөнгө

Бараг мөнгө 2018 онд 15.4 их наяд төгрөг болж, 2014 оноос 6.6 их наяд төгрөгөөр буюу 42.9 хувь, 2015 оноос 7.1 их наяд төгрөгөөр буюу 45.9 хувь, 2016 оноос 5.4 их наяд төгрөгөөр буюу 35.2 хувиар өссөн байна. 2018 онд өмнөх оноос 2.4 их наяд төгрөгөөр буюу 15.6 хувиар өссөн нь төгрөгийн хадгаламж 1.5 (63.7%) их наяд төгрөгөөр, гадаад валютын харилцах 386.7 (16.1%) тэрбум төгрөгөөр, гадаад валютын хадгаламж 487.6 (20.2%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна (Хүснэгт 1).

Бараг мөнгөнд валютын хадгаламжийн эзлэх хувь 2018 онд 19.6 хувь болж өмнөх оноос 0.1 пунктээр, гадаад валютын харилцах 14.7 хувь болж өмнөх оноос 0.3 пунктээр өссөн бол төгрөгийн хадгаламжийн эзлэх хувь 65.8 болж өмнөх оноос 0.4 пунктээр буурсан байна (Зураг 6).

ЗУРАГ 6. БАРАГ МӨНГӨНИЙ БҮТЭЦ, хувиар



- **Хадгаламж**

Иргэд, байгууллагын нийт хадгаламж 2018 оны эцэст 13.2 их наяд төгрөг болж, 2014 оноос 5.8 их наяд төгрөгөөр буюу 78.6 хувиар, 2015 оноос 5.8 их наяд төгрөгөөр буюу 78.5 хувиар, 2016 оноос 4.6 их наяд төгрөгөөр буюу 53.6 хувиар, 2017 оноос 2.0 их наяд төгрөгөөр буюу 18.1 хувиар тус тус өсжээ. Нийт хадгаламж өмнөх оноос өсөхөд валютын хадгаламж 487.6 тэрбум төгрөг буюу 19.3 хувь, төгрөгийн хадгаламж 1.5 их наяд төгрөгөөр буюу 17.8 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна (Хүснэгт 2). Нийт хадгаламжид 2018 оны эцэст төгрөгийн хадгаламж 77.1 хувь, гадаад валютын хадгаламж 22.9 хувийг тус тус эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд төгрөгийн хадгаламжийн өсөлт илүү хурдацтай болж, валютын хадгаламжийн өсөлт саарч байгаа хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, төгрөгийн хадгаламж 2016 онд 0.4 их наяд төгрөгөөр буюу 6.5 хувиар, 2017 онд 2.8 их наяд төгрөгөөр буюу 48.9 хувиар, 2018 онд 1.5 их наяд төгрөгөөр буюу 17.8 хувиар өсөж, жилийн цэвэр өсөлт 2016 онд 6.1 пунктээр, 2017 онд 42.4 пунктээр өсөж байсан бол 2018 онд 31.1 пунктээр саарчээ (Хүснэгт 2).

Гадаад валютын хадгаламж 2017 онд 257.8 тэрбум төгрөгөөр буюу 9.2 хувиар буурч, 2016 онд 841.9 тэрбум төгрөгөөр буюу 43.2 хувиар, 2018 онд 487.6 тэрбум төгрөгөөр буюу 19.3 хувиар тус тус өссөн байна. Валютын хадгаламжийн жилийн цэвэр өсөлт 2017 онд 52.4 пунктээр саарч байсан ч 2018 онд 28.6 пунктээр нэмэгджээ (Хүснэгт 2).

ХҮСНЭГТ 2. НИЙТ ХАДГАЛАМЖ, жил бүрийн эцэст


Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Нийт хадгаламж, тэрбум төг	7 378.9	7 381.8	8 579.6	11 153.9	13 175.8
Жилийн өөрчлөлт, хувиар	15.6	0.04	16.2	30	18.1
Төгрөгийн хадгаламж, тэрбум төг	5 410.3	5 434.0	5 789.9	8 622.0	10 156.3
Жилийн өөрчлөлт, хувиар	10.2	0.4	6.5	48.9	17.8
Нийт хадгаламжид эзлэх хувь	73.3	73.6	67.5	77.3	77.1
Валютын хадгаламж, тэрбум төг	1 968.6	1 947.8	2 789.7	2 531.9	3 019.5
Жилийн өөрчлөлт, хувиар	33.5	-1.1	43.2	-9.2	19.3
Нийт хадгаламжид эзлэх хувь	26.7	26.4	32.5	22.7	22.9

I.2 НӨӨЦ МӨНГӨ (M0)

Нөөц мөнгө 2018 оны эцэст 4.9 их наяд төгрөг болж, өмнөх оноос 963.4 тэрбум төгрөгөөр буюу 24.5 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд банкуудын харилцах, хадгаламж 903.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлжээ. Нөөц мөнгөний жилийн цэвэр өсөлт 2017 онд 28.5 хувь байсан бол 2018 онд 24.5 хувь болж, өсөлтийн хурдац 4.1 пунктээр буурсан байна.

Манай улсын нөөц мөнгөний 2013-2018 оны 6 жилийн тоо мэдээлэлд үндэслэн улирлын хэлбэлзлийг тооцож үзэхэд нөөц мөнгөний индекс 1-3 сарын турш буурч, 4-7 дугаар сард өсөж, 8-10 дугаар саруудад эргээд буурч, 11-р сараас өсөж улмаар 12 дугаар сард дээд цэгтээ хүрчээ. 2018 оны улирлын индекс 3 дугаар сард 91.7 хувь буюу хамгийн бага, 12 дугаар сард 110.7 хувь буюу хамгийн өндөр үзүүлэлттэй байна (Зураг 7).

ЗУРАГ 7. НӨӨЦ МӨНГӨ (M0)-НИЙ ЗАСВАРЛАСАН УЛИРЛЫН ИНДЕКС, 2018 он, сараар




Нөөц мөнгөнд банкнаас гадуурх мөнгө 2016 онд 562.9 тэрбум төгрөг буюу 18.4 хувь, 2017 онд 611.8 тэрбум төгрөг буюу 15.5 хувь, 2018 онд 670.5 тэрбум төгрөг буюу 13.7

хувийг эзэлж байна. Банкнаас гадуурх мөнгө 2018 онд өмнөх оноос 58.8 тэрбум төгрөгөөр буюу 9.6 хувиар, 0.9 пунктээр тус тус өссөн байна.

Төв банкин дахь банкуудын харилцах, төгрөгийн хадгаламж 2016 онд 2.2 их наяд төгрөг болж 73.2 хувийг, 2017 онд 3.0 их наяд төгрөг болж 77.1 хувийг, 2018 онд 3.9 их наяд төгрөг болж 29.7 хувийг эзэлж, 2018 онд өмнөх оноос 903.0 тэрбум төгрөгөөр буюу 29.7 хувиар өссөн хэдий ч өмнөх оноос 5.6 пунктээр буурсан байна.

Банкуудын кассанд дахь мөнгө 2016 онд 258.6 тэрбум төгрөг болж 8.4 хувийг, 2017 онд 291.2 тэрбум төгрөг болж 7.4 хувийг, 2018 онд 292.9 тэрбум төгрөг болж 6.0 хувийг эзэлж байна. Банкуудын кассанд дахь мөнгө 2018 онд өмнөх оноос 1.6 тэрбум төгрөгөөр буюу 0.6 хувиар өсөж, өмнөх оноос 12.0 пунктээр буурчээ (Зураг 8).

ЗУРАГ 8. НӨӨЦ МӨНГӨ (М0)-НИЙ БҮТЭЦ, хувиар



Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсэг болох банкнаас гадуурх мөнгөний улирлын хэлбэлзлийн индекс 2018 оны 1-р улирлын турш буурч, 4,5 дугаар саруудад өссөн ч 6,7 дугаар сард эргээд буурч, 8-р сард өсөж хамгийн дээд цэгтээ хүрэн улмаар 8-12 дугаар сард буурч 12 дугаар сард хамгийн доод цэгтээ хүрдэг байна. Улирлын индекс 12 дугаар сард 91.6 хувь буюу хамгийн бага, 8 дугаар сард 109.8 хувь буюу хамгийн өндөр үзүүлэлттэй байна (Зураг 9).

ЗУРАГ 9. БАНКНААС ГАДУУРХ МӨНГӨНИЙ ЗАСВАРЛАСАН УЛИРЛЫН ИНДЕКС, 2018 он, сараар



I.3 МӨНГӨНИЙ ҮРЖҮҮЛЭГЧ

Мөнгөний үржүүлэгч нь банкны систем нөөц мөнгийг хэд дахин өсгөж нийт мөнгө болгож байгааг илэрхийлдэг үзүүлэлт юм. Мөнгөний үржүүлэгч өндөр байх нь эдийн засагт бага хэмжээний нөөц мөнгөөр их хэмжээний мөнгөний нийлүүлэлтийг бий болгож байгааг илэрхийлдэг.

ХҮСНЭГТ 3. МӨНГӨНИЙ ҮРЖҮҮЛЭГЧ

	2014	2015	2016	2017	2018
Мөнгөний нийлүүлэлт (M2), сая төг	10 634 330.7	10 048 995.8	12 158 529.9	15 861 198.5	19 474 697.6
Нөөц мөнгө (M0), сая төг	3 299 028.0	2 459 596.1	3 064 435.9	3 939 093.4	4 902 514.5
Мөнгөний үржүүлэгч	3.22	4.09	3.97	4.03	3.97

Эх үүсвэр: Монголбанк


Мөнгөний үржүүлэгч 2017 онд 4.03 байсан бол 2018 онд өмнөх оныхоос 0.1 пунктээр буурч 3.97 болсон байна. Өөрөөр хэлбэл манай орны хувьд эдийн засаг дахь нөөц мөнгө 4 дахин өсөж байна гэсэн үг юм (Хүснэгт 3).

I.4 ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2018 оны эцэст 2015 оноос 262.0 (37.1%) тэрбум төгрөгөөр, 2016 оноос 145.0 (17.6%) тэрбум төгрөгөөр, 2017 оноос 62.2 (6.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. 2018 онд гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 30.8 хувийг касст байгаа бэлэн мөнгө, 69.2 хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө эзэлж байна.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2018 оны 1 дүгээр сард хамгийн их буюу 11.5 хувиар буурсан бол 4 дүгээр сард 11.6 хувиар өссөн байна (Зураг 10).

ЗУРАГ 10. ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨНИЙ ӨӨРЧЛӨЛТ, хувиар, 2018 он, сараар




1.5 ВАЛЮТЫН ХАНШ, ДОЛЛАРЖИЛТ

- **Валютын ханш**

Төв банкны нэрлэсэн жилийн дундаж ханш 2018 онд төгрөгийн ам.долларттай харьцах ханш 2472.67 болж өмнөх оноос 1.3 хувиар, евротой харьцах ханш 2918.78 болж өмнөх оноос 5.8 хувиар, юаньтай харьцах ханш 373.88 болж өмнөх оноос 3.5 хувиар тус тус суларч, рубльтэй харьцах ханш 39.49 болж өмнөх оноос 5.7 хувиар чангарсан байна. (Зураг 11).

ЗУРАГ 11. ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ ТӨВ БАНКНЫ НЭРЛЭСЭН ДУНДАЖ ХАНШНЫ ӨӨРЧЛӨЛТ, сар бүрийн эцэст, хувиар



Төгрөгтэй харьцах гадаад валютын ханш 2018 оны жилийн эцэс /2018 оны 12 дугаар сарын эцэст/-т ам.доллартой харьцах дундаж ханш 2463.69 төгрөг болж өмнөх оноос 1.3 хувиар, евротой харьцах ханш 3024.65 төгрөг болж өмнөх оноос 4.4

хувиар, юаньтай харьцах дундаж ханш 384.34 төгрөг болж 3.4 хувиар суларч, рубльтэй харьцах дундаж ханш 37.97 төгрөг болж 9.9 хувиар чангарсан байна. (Хүснэгт 4).


ХҮСНЭГТ 4. ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ ТӨВБАНКНЫ ЗАРЛАСАН ХАНШ, төгрөгөөр

Гадаад валют	2014	2015	2016	2017	2018
Гадаад валютын ханш, жилийн дундаж					
АНУ-ын доллар	1 818.28	1 970.66	2 147.74	2 440.63	2 472.67
Евро	2 414.27	2 187.42	2 181.67	2 757.59	2 918.78
Рубль	48.05	32.46	32.17	41.88	39.49
Юань	295.11	313.53	313.12	361.33	373.88
Вон	1.73	1.74	1.74	2.16	2.25
Иен	17.21	16.29	16.34	21.76	22.39
Фунт	2 994.67	3 011.98	3 009.65	3 145.04	3 298.44
Гадаад валютын ханш, жилийн эцэст					
АНУ-ын доллар	1 888.44	1 995.51	2 489.53	2 427.13	2 463.69
Евро	2 295.40	2 181.19	2 605.79	2 897.87	3 024.65
Рубль	33.97	27.02	41.03	42.12	37.97
Юань	304.59	307.3	357.96	371.58	384.34
Вон	1.73	1.7	2.06	2.27	2.37
Иен	15.78	16.57	21.19	21.53	23.98
Фунт	2 938.98	2 958.14	3 057.89	3 264.73	3 364.89

• Долларжилт

Долларжилт өндөр байх нь мөнгөний хараат бус байдлаа алдах болон төв банкны мөнгөнд тавих хяналтад саад болсноор бодлого боловсруулагчдад хүндрэл учруулдаг. Активийн долларжилтын явцыг 2014-2018 оноор авч үзэхэд дараах байдалтай байна (Зураг 12).

ЗУРАГ 12. ДОЛЛАРЖИЛТ, хувиар



Манай улс дунд зэргийн долларжилттай оронд багтдаг ба 2014-2018 онуудад долларжилт дунджаар 30.1 хувьтай байв. Долларжилтийн түвшин 2014-2016 онд дунджаар 31.1 хувь хүртэл өссөн боловч 2017 онд 29.5 хувь болж буурч, 2018 онд 28.0 хувь болж өмнөх оноос 1.5 пунктээр буурчээ.

I.6 САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР, МӨНГӨЖҮҮЛЭЛТ

Эдийн засагт мөнгөжих үйл явц эрчимтэй үргэлжилсний дүнд санхүүгийн зуучлалын гүнзгийрэлт үргэлжилж, гол үзүүлэлтүүдийн нэг болох нийт мөнгө (M2) болон ДНБ-ий оны үнийн харьцаа 2005 онд 37.5 хувь, 2010 онд 48.0 хувь, 2017 онд 56.9 хувь, 2018 онд 60.7 хувь болж өссөн байна. 2018 онд өмнөх оноос 3.8 пунктээр өсжээ.


Хадгаламж болон ДНБ-ий оны үнийн харьцаа 2018 онд 40.7 хувь болж өмнөх оноос 1.0 пунктээр, зээлийн өрийн үлдэгдэл болон ДНБ-ий оны үнийн харьцаа 2018 онд 53.2 хувь болж өмнөх оноос 4.4 пунктээр тус тус өсжээ (Хүснэгт 5).

ХҮСНЭГТ 5. МӨНГӨ, ЗЭЭЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, хувиар

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Мөнгөний нийлүүлэлт (M2)/ДНБ-ий оны үнэ, хувь	47.8	43.4	50.8	56.9	60.7
Зээл/ДНБ-ий оны үнэ, хувь	56.3	50.6	51.9	48.8	53.2
Хадгаламж/ДНБ-ий оны үнэ, хувь	33.2	31.7	35.6	39.8	40.7
Мөнгөний эргэлтийн хурд	2.1	2.3	2.0	1.8	1.6

Мөнгөний эргэлтийн хурд 2016 онд 2.0 хувь болж өмнөх оноос 0.3 пунктээр, 2017 онд 1.8 хувь болж өмнөх оноос 0.2 пунктээр, 2018 онд 1.6 хувь болж өмнөх оноос 0.1 пунктээр буурсан байна (Зураг 13).

ЗУРАГ 13. МӨНГӨ, ЗЭЭЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, хувиар





Зээл, тэрбум төгрөг



Зээлийн хүү, хувиар

Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү



Валютын зээлийн жигнэсэн дундаж хүү



Зээлийн өрийн үлдэгдэл, тэрбум.төг

Зээлийн өрийн нийт үлдэгдэл



II.1 ЗЭЭЛ

Банкны системийн дүнгээр 2018 онд нийт 22.1 их наяд төгрөгийн зээл олгосон нь өмнөх оноос 8.0 их наяд төгрөг буюу 55.8 хувиар өсжээ. Зээл олголтыг өмнөх оны мөн үеийн улирал тус бүрээр авч үзвэл 2018 оны 1 дүгээр улиралд 34.8 хувиар өсөж 3.9 их наяд төгрөг, 2 дугаар улиралд 57.1 хувиар өсөж 5.8 их наяд төгрөг, 3 дугаар улиралд 48.9 хувиар өсөж 5.3 их наяд төгрөг, 4 дүгээр улиралд 75.6 хувиар өсөж 7.1 их наяд төгрөгийн зээл олгосон байна (Хүснэгт 6).

Зээлийн эргэн төлөлт 2018 онд 18.3 их наяд төгрөг болж өмнөх оноос 5.9 их наяд төгрөг буюу 47.4 хувиар өсжээ. Зээл төлөлтийг өмнөх оны мөн үеийн улирал тус бүрээр авч үзвэл 2018 оны 1 дүгээр улиралд 30.8 хувиар өсөж 3.2 их наяд төгрөг, 2 дугаар улиралд 45.4 хувиар өсөж 4.6 их наяд төгрөг, 3 дугаар улиралд 41.3 хувиар өсөж 4.4 их наяд төгрөг, 4 дүгээр улиралд 65.5 хувиар өсөж 6.0 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдсөн (Хүснэгт 6).

ХҮСНЭГТ 6. ОЛГОСОН БОЛОН ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ, улирлаар

Үзүүлэлт	2017				2018			
	I	II	III	IV	I	II	III	IV
Олгосон зээл, тэрбум төгрөг	2 877.6	3 718.0	3 567.7	4 049.2	3 877.8	5 839.7	5 311.9	7 108.7
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар	25.6	14.8	33.7	30.9	34.8	57.1	48.9	75.6
Төлөгдсөн зээл, тэрбум төгрөг	2 467.8	3 165.5	3 140.5	3 634.5	3 227.3	4 602.6	4 438.8	6 014.8
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар	11.1	9.7	20.9	6.6	30.8	45.4	41.3	65.5


Зээлийг хугацаагаар нь авч үзвэл 2018 оны эцэст 42.5 хувь нь нэг жил хүртэлх, 46.2 хувь нь 1-5 жил хүртэлх, 11.3 хувь нь 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээл олгосон байна.

II.2 ЗЭЭЛИЙН ХҮҮ

Зээлийн хүүгийн түвшинд Төв банкны үнэт цаасны хүү, хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, мөнгөний нийлүүлэлт, хадгаламж, зээл, татварын дарамт зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг.

Нийт банкны салбарын хэмжээгээр төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2018 оны эцэст 16.9 хувь болж өмнөх оноос 2.1 пунктээр, валютын зээлийн жигнэсэн дундаж хүү 8.8 хувь болж өмнөх оноос 2.8 пунктээр тус тус буурчээ (Зураг 14).

ЗУРАГ 14. ЗЭЭЛИЙН ЖИЛИЙН ХҮҮ, сарын эцэст, хувиар



Эх үүсвэр: Монголбанк

Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2017 онд сард дунджаар 20.0 хувь, 2018 онд сард дунджаар 18.3 хувь болж өмнөх оноос 1.8 пунктээр буурсан байна. Валютын зээлийн хүү 2017 онд сард дунджаар 11.7 хувь, 2018 онд сард дунджаар 10.1 хувь болж өмнөх оноос 1.6 пунктээр буурчээ.

II.3 ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны эцэст 17.2 их наяд төгрөг болж өмнөх оноос 3.6 их наяд төгрөг буюу 26.5 хувиар өсжээ (Хүснэгт 6). Зээлийн өрийн үлдэгдэлд хэвийн зээл 14.6 их наяд буюу 84.7 хувийг, хугацаа хэтэрсэн зээл 0.8 их наяд төгрөг буюу 4.9 хувийг, чанаргүй зээл 1.8 их наяд төгрөг буюу 10.4 хувийг тус тус эзэлж байна (Хүснэгт 7).

ХҮСНЭГТ 7. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЛИЙН ТӨРӨЛ, жилийн эцэст

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Зээлийн өрийн үлдэгдэл, тэрбум төгрөг	12 503.5	11 706.6	12 422.7	13615.1	17225.7
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	16.1	-6.4	6.1	9.6	26.5
Хэвийн зээл, тэрбум төгрөг	11 608.3	9 982.8	10 466.7	11638.8	14592.4
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	15.1	-14.0	4.8	11.2	25.4
Хугацаа хэтэрсэн зээл, тэрбум төгрөг	269.5	854.0	904.3	823.3	848.8
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	1.3 ¹	2.2	5.9	-9.0	3.1
Чанаргүй зээл, тэрбум төгрөг	625.7	869.8	1 051.7	1 153.0	1 784.5
Жилийн цэвэр өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	10.6	39.0	20.9	9.6	54.8
Зээлийн өрийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь	2.2	7.3	7.3	6.0	4.9
Зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь	5.0	7.4	8.5	8.5	10.4

¹ дахин их

Зээлийн өрийн үлдэгдлийн сарын дундаж өсөлт 2014 онд өмнөх оноос 1.3 хувиар өсөж, 2015 онд өмнөх оноос 0.5 хувиар буурч, 2016 онд 0.5 хувиар, 2017 онд 0.8 хувиар, 2018 онд 2.0 хувиар өссөн байна.

ЗУРАГ 15. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, жилийн цэвэр өөрчлөлт, хувиар



- **Хугацаа хэтэрсэн зээл**

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны эцэст 848.7 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 25.5 тэрбум төгрөг буюу 3.1 хувиар өсжээ (Хүснэгт 7).

Нийт зээлийн өрийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 4.9 хувийг эзэлж, өмнөх оноос 1.1 пунктээр буурсан байна. Хугацаа хэтэрсэн зээл 2017 онд сард дунджаар 0.3 хувь буурч байсан бол 2018 онд сард дунджаар 0.8 хувиар өссөн байна.

- **Чанаргүй зээл**


Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2018 оны эцэст 1.8 их наяд төгрөг болж, өмнөх оныхоос 631.5 тэрбум төгрөг буюу 54.8 хувиар өсжээ (Хүснэгт 7).

Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.4 хувийг эзэлж, өмнөх оноос 1.9 пунктээр өссөн байна. Чанаргүй зээл 2017 онд сард дунджаар 0.8 хувиар, 2018 онд сард дунджаар 4.4 хувиар өссөн байна.

II.3.1 Зээлийн өрийн үлдэгдэл, салбараар

Нийт зээлийн өрийн үлдэгдэлд 2018 оны эцэст 0.7 хувийг төрийн байгууллага, 46.2 хувийг хувийн байгууллага, 52.6 хувийг иргэд, 0.6 хувийг санхүүгийн болон бусад байгууллага тус тус эзэлж байна (Зураг 16).

ЗУРАГ 16. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, салбараар, хувиар



- **Аж ахуйн нэгж, байгууллагын зээлийн өрийн үлдэгдэл**

Зээлийн өрийн үлдэгдлийг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл 2018 онд нийт зээлийн өрийн үлдэгдэлд хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагааны салбар 120.2 тэрбум төгрөг болж 0.7 хувийг эзэлж, өмнөх оноос 0.2 пунктээр, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар 340.0 тэрбум төгрөг болж 2.0 хувийг эзэлж, өмнөх оноос 0.6 пунктээр тус тус өссөн бол боловсролын салбар 117.2 тэрбум төгрөг болж 0.7 хувийг эзэлж, өмнөх оноос 0.1 пунктээр, хөдөө аж ахуйн салбар 331.4 тэрбум төгрөг болж 1.9 хувийг эзэлж, өмнөх оноос 0.4 пунктээр, уул уурхай, олборлолтын салбар 1233.1 тэрбум төгрөг болж 7.2 хувийг эзэлж, өмнөх оноос 0.4 пунктээр буурсан байна (Хүснэгт 8).

ХҮСНЭГТ 8. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, салбараар, жилийн эцэст

Үйл ажиллагааны салбар	2016		2017		2018	
	Зээлийн өр, тэрбум төгрөг	Эзлэх хувь	Зээлийн өр, тэрбум төгрөг	Эзлэх хувь	Зээлийн өр, тэрбум төгрөг	Эзлэх хувь
Зээлийн өрийн үлдэгдлийн дүн, тэрбум төгрөг	12422.7	100.0	13615.1	100.0	17225.7	100.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	282.9	2.3	310.5	2.3	331.4	1.9
Хөдөө аж ахуй	-	-	-	-	122.1	0.7
Газар тариалан	-	-	-	-	207.2	1.2
Уул уурхай, олборлолт	761.7	6.1	1034.3	7.6	1233.1	7.2
Боловсруулах үйлдвэрлэл	1294.3	10.4	1372.6	10.1	1446.3	8.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	113.5	0.9	59.7	0.4	116.1	0.7
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	9.7	0.1	9.1	0.1	8.9	0.1
Барилга	1333.8	10.7	1261.3	9.3	1507.4	8.8
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1741.9	14.0	1864.4	13.7	2411.3	14.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	155.9	1.3	189.9	1.4	340.0	2.0
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	250.8	2.0	286.0	2.1	324.9	1.9
Мэдээлэл, холбоо	83.7	0.7	44.2	0.3	66.6	0.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	464.8	3.7	387.8	2.8	467.9	2.7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1968.6	15.8	1905.0	14.0	1823.6	10.6
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	10.4	0.1	19.0	0.1	43.0	0.2
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	138.9	1.1	125.1	0.9	55.8	0.3
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2.2	0.02	1.9	0.01	2.3	0.01
Боловсрол	132.5	1.1	112.3	0.8	117.2	0.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	78.0	0.6	72.5	0.5	120.2	0.7
Бусад	3599.1	29.0	4559.5	33.5	6809.7	39.5

- **Хувийн салбарын зээлийн өрийн үлдэгдэл**

Хувийн салбарын зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны эцэст 8.0 их наяд төгрөг болж нийт зээлийн өрийн үлдэгдлийн 46.2 хувийг эзэлж, өмнөх оноос 1.2 тэрбум төгрөгөөр буюу 16.9 хувиар өсжээ (Хүснэгт 9).

ХҮСНЭГТ 9. ХУВИЙН САЛБАРЫН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, төрлөөр, жилийн эцэст

	2014	2015	2016	2017	2018
Зээлийн өрийн үлдэгдлийн дүн, тэрбум төгрөг	12 503.5	11 706.6	12 422.7	13615.1	17225.7
Хувийн салбарын зээлийн өрийн үлдэгдлийн дүн, тэрбум төгрөг	6 619.3	6 408.3	6 640.1	6 806.2	7 957.1
Хэвийн зээл, тэрбум төгрөг	5 868.4	4 930.0	5 004.4	5 179.6	5 727.7
Хугацаа хэтэрсэн зээл, тэрбум төгрөг	196.6	740.9	781.1	696.7	710.0
Чанаргүй зээл, тэрбум төгрөг	554.3	737.4	854.6	929.9	1 519.4

Хувийн салбарын зээлийн өрийн үлдэгдлийн хугацаа хэтэрсэн зээл нь 2018 оны эцэст 710.0 тэрбум төгрөг болж нийт хугацаа хэтэрсэн зээлийн 83.7 хувийг эзэлж, өмнөх оноос 13.3 тэрбум төгрөг буюу 1.9 хувиар өссөн байна.

Хувийн салбарын зээлийн өрийн үлдэгдлийн чанаргүй зээл нь 2018 оны эцэст 1519.4 тэрбум төгрөг болж нийт чанаргүй зээлийн 85.1 хувийг эзэлж, өмнөх оноос 589.5 тэрбум төгрөг буюу 63.4 хувиар өссөн байна.

II.3.2 Иргэдийн зээлийн өрийн үлдэгдэл


Иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны эцэст 11.8 их наяд төгрөг болж, өмнөх оноос 2.6 их наяд төгрөгөөр буюу 28.6 хувиар өссөн байна (Хүснэгт 10).

ХҮСНЭГТ 10. ИРГЭДИЙН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, төрлөөр, жилийн эцэст

	2017		2018	
	Зээлийн өр, тэрбум төгрөг	Эзлэх хувь	Зээлийн өр, тэрбум төгрөг	Эзлэх хувь
Иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн дүн, тэрбум төгрөг	9 162.4	100.0	11 780.0	100.0
Ипотек	4 253.2	46.4	4 430.2	37.6
Жижиг дунд үйлдвэр	808.5	8.8	1 195.5	10.1
Хэрэглээ	679.8	7.4	1 190.1	10.1
Цалин	2 131.6	23.3	3 456.7	29.3
Тэтгэвэр	695.2	7.6	925.4	7.9
Бусад	594.1	6.5	582.1	4.9

Иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэлд 2018 оны эцэст ипотекийн зээл 4.4 их наяд төгрөг болж өмнөх оноос 117.0 тэрбум төгрөгөөр буюу 4.2 хувиар, жижиг дунд үйлдвэрийн зээл 1.2 их наяд төгрөг болж, өмнөх оноос 387.0 тэрбум төгрөгөөр буюу 47.9 хувиар, хэрэглээний зээл 1.2 их наяд төгрөг болж өмнөх оноос 510.0 тэрбум төгрөгөөр буюу 75.1 хувиар, тэтгэврийн зээл 0.9 их наяд төгрөг болж өмнөх оноос 230.2 тэрбум төгрөгөөр буюу 33.1 хувиар тус тус өсөж харин бусад зээл 0.6 их наяд төгрөг болж өмнөх оноос 12.0 тэрбум төгрөгөөр буюу 2.0 хувиар буурсан байна (Зураг 17).

ЗУРАГ 17. ИРГЭДИЙН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, төрлөөр, тэрбум төгрөг



ҮНЭТ ЦААС



БОНДЫН АРИЛЖАА

	2017	2018
Засгийн газрын (сая төг)	630 204.9	-
Компанийн (сая төг)	3380.4	631.6
ЗГҮЦаасны хоёрдогч зах зээлийн арилжаа* сая төг	614 738.7	116 329.1

ТОП-20 ИНДЕКС

	2017	2018
Дундаж	15 511.9	20 076.5
Хамгийн их	24 520.4	21 466.8
Хамгийн бага	11 972.1	19 387.1

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Монголын хөрөнгийн биржид 2018 оны эцэст үнэт цаас нь бүртгэгдсэн 216 компани бүртгэлтэй байгаагаас төрийн өмчийн компани 18 буюу 8.3 хувийг, төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани 11 буюу 5.1 хувийг, хувийн өмчийн компани 187 буюу 86.8 хувийг тус тус эзэлж байна (Хүснэгт 11).

Үнэт цаасны арилжаа 2018 онд нийт 252 өдөр явагдаж, 666.8 сая ширхэг хувьцааг 210.0 тэрбум төгрөгөөр арилжсан нь өмнөх оноос хувьцаа 560.7 сая ширхэгээр, арилжааны гүйлгээ 133.6 тэрбум төгрөгөөр өсжээ.

2018 оны эцэст Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч захын арилжаагаар 332.9 мянган ширхэг хувьцааг 33.5 тэрбум төгрөгөөр, 6.3 мянган ширхэг компанийн бондыг 631.6 сая төгрөгөөр арилжсан байна (Хүснэгт 11, 12, 13).

ХҮСНЭГТ 11. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Бүртгэлтэй компанийн тоо	237	235	227	218	216
Зах зээлийн үнэлгээ (сая төг)	1 442 655.4	1 262 497.5	1 474 173.3	2 436 324.5	2 508 040.9
Хувьцааны арилжаа					
Үнийн дүн (сая төг)	24 241.8	30 477.4	49 046.8	76 449.0	210 002.2
Арилжигдсан хувьцааны тоо (сая ш)	51.7	35.8	93.7	106.1	666.8
Бондын арилжаа					
Засгийн газрын (сая төг)	36 116.9	510 340.0	280 451.9	630 204.9	-
Компанийн (сая төг)	-	459.7	-	3380.4	631.6
ЗГҮЦаасны хоёрдогч зах зээлийн арилжаа* сая төг	135 921.4	357 243.7	133 392.3	614 738.7	116 329.1
ТОП-20 индекс					
дундаж	15 745.0	13 434.2	11 550.1	15 511.9	20 076.5
хамгийн их	17 160.5	15 737.2	12 939.5	24 520.4	21 466.8
хамгийн бага	14 475.2	11 962.1	10 485.7	11 972.1	19 387.1
хаалт	14 854.2	12 897.6	12 456.1	20 736.9	21 466.8
Хийгдсэн хэлцлийн тоо (мянга)	13.4	11.5	14.8	38.2	66.9
Брокер, дилерийн компанийн тоо	62	58	58	58	59

- **Хувьцааны арилжаа**

2018 онд өдөрт дунджаар 2646.2 мянган хувьцаа арилжаалж, 833.3 сая төгрөгийн гүйлгээ хийжээ (Хүснэгт 12).

ХҮСНЭГТ 12. ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

	2014	2015	2016	2017	2018
Арилжаа явсан өдрийн тоо	255	252	244	249	252
Арилжигдсан хувьцааны тоо					
Нийт (сая.ш)	51.7	35.8	93.7	106.1	666.8
Өдрийн дундаж (мян.ш)	202.8	142.2	384.1	426.1	2 646.2
Үнийн дүн (сая төг)					
Нийт	24 241.8	30 477.4	49 046.7	76 449.0	210 002.2
Өдрийн дундаж	95.1	120.9	201	307	833.3

ЛэндМН ББСБ, АПУ, Хай Би Ойл, Айтүүлс, Женко тур бюро компаниудын үнэт цаас 2018 онд хамгийн их идэвхтэй арилжигдсан байна.

- **Засгийн газрын үнэт цаасны арилжаа**

Хөрөнгийн биржээр 2018 онд Засгийн газрын үнэт цаасны 83 удаагийн арилжаагаар 332.9 мян.ш үнэт цаасыг 34.5 тэрбум төгрөгөөр арилжлаа. Нийт арилжигдсан үнийн дүнг хөрөнгө оруулагчдаар авч үзвэл бизнесийн байгууллагууд 32.4 тэрбум төгрөг буюу 94 хувийг, хувь хүмүүс 2.1 тэрбум төгрөг буюу 6.0 хувийг эзэлж байна (Хүснэгт 13).


ХҮСНЭГТ 13. ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН АРИЛЖАА

	2014	2015	2016	2017	2018
Арилжаа явсан өдрийн тоо	9	51	82	171	83
Арилжигдсан бондын тоо (мян.ш)					
Нийт	37.5	5 387.9	3 250.1	8 203.0	332.9
Өдрийн дундаж	41.7	105.6	39.6	48	4
Үнийн дүн (сая.төг)					
Нийт	36 116.9	510 340.0	299 638.0	773 490.3	34 486.9
Өдрийн дундаж	4 013.0	10 006.7	3 654.1	4 523.3	415.5
Үнийн дүн, хөрөнгө оруулагчдаар (сая төг)					
Арилжааны банкууд	18 320.7	455 006.6	97 889.2	247 048.9	-
Бизнесийн байгууллагууд	8 144.9	26 919.9	39 445.0	187 773.7	32 418.1
Хувь хүмүүс	9 621.4	27 841.6	25 514.0	159 576.6	2 068.8
Төрийн бус байгууллагууд	29.9	571.9	609.9	-	-
Бусад	-	-	136 179.9	179 091.1	-

- **Зах зээлийн үнэлгээ**

Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2018 оны эцэст 2 508.0 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 71.7 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар өслөө. (Зураг 18).

ЗУРАГ 18. ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, жилийн эцэст, тэрбум төг




АПУ, Таван толгой, МИК Холдинг, Говь ХК, Сүү ХК зэрэг хувьцаат компани зах зээлийн хамгийн өндөр үнэлгээтэй 5 компани орж байна.

- **ТОП-20 индекс**

Монголын хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэгч гол үзүүлэлтүүдийн нэг ТОП-20 дундаж индекс 2017 онд 15 511.9 байсан бол 2018 онд 20 076.5 болж 4 564.6 нэгжээр өссөн байна (Зураг 19).

ЗУРАГ 19. ТОП-20 ДУНДАЖ ИНДЕКС, жил бүрийн дундаж



2018 онд ТОП-20 дундаж индексийн хамгийн өндөр үзүүлэлт 21 466.8 нэгж, хамгийн бага 19 387.1 нэгж болжээ.

САНХҮҮГИЙН БУСАД САЛБАР

IV.1 ДААТГАЛ

Дэлхийн хүн амын дийлэнх хэсэг нь арилжааны даатгалд даатгуулах замаар амьдралын хэвийн байдлыг алдагдуулж, хохирол учруулж болзошгүй байгалийн гамшиг, гал твймэр, газар хөдлөлт, ган зуд, үер, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, өвчин эмгэг, золгүй явдал, осол гэмтлээс хамгаалсан байдаг.

ХҮСНЭГТ 14. ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Даатгалын хураамжийн орлого, сая төг	108 746.7	114 312.8	114 501.9	144 338.4	178 704.8
Нөхөн төлбөр, сая төг	30 860.6	32 970.0	34 291.5	45 238.6	58 212.6
Даатгалын нөөцийн сангийн өөрчлөлт, сая төг	14 408.4	6 717.3	20 208.0	25 014.1	27 992.0
Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагын тоо	17	17	17	17	18
Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагын ажиллагчдын тоо	1 183	1 122	1 171	1 355	1 342

Манай улсад 2018 онд нийт 18 байгууллага даатгалын үйл ажиллагаа явуулсан байна. Даатгалын байгууллагууд 2018 онд 178.7 тэрбум төгрөгийн хураамжийн орлого олж, 58.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр төлжээ. Хураамжийн орлого 2017 оноос 34.4 тэрбум төгрөгөөр буюу 23.8 хувиар, нөхөн төлбөр 13.0 тэрбум төгрөгөөр буюу 28.7 хувиар өслөө (Хүснэгт 14).

IV.2 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Улсын хэмжээнд 2018 онд нийт 539 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж, 259.5 тэрбум төгрөгийн санхүүгийн орлого олж, 158.4 тэрбум төгрөгийг санхүүгийн зардалд зарцуулж, 77.2 тэрбум төгрөгийн санхүүгийн цэвэр ашигтай ажилласан байна (Хүснэгт 15).

ХҮСНЭГТ 15. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ


Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Санхүүгийн орлого, сая төг	127 105.2	152 188.6	188 165.2	195 883.0	259 496.4
Санхүүгийн зардал, сая төг	44 752.8	39 423.9	104 286.0	93 503.2	158 365.2
Болзошгүй эрсдлийн зардал, сая төг	11 380.9	16 433.3	21 185.9	24 407.8	23 965.2
Санхүүгийн цэвэр ашиг, сая төг	70 971.5	96 331.4	62 693.4	42 369.5	77 166.0
Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулсан банк бус санхүүгийн байгууллагын тоо	378	450	518	534	539

Санхүүгийн орлого 2018 онд өмнөх оноос 32.5 хувь, санхүүгийн цэвэр ашиг (санхүүгийн орлогоос санхүүгийн зардал болон болзошгүй эрсдэлийн зардлыг хассан дүн) 82.1 хувь, санхүүгийн зардал 69.4 хувиар өсжээ (Хүснэгт 15).

IV.3 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Тусгай зөвшөөрөлтэй 279 аж ахуй нэгж байгууллага 2018 онд үйл ажиллагаа явуулж, 39.6 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олж, 23.1 тэрбум төгрөгийг хүүгийн төлбөрт зарцуулж, 16.5 тэрбум төгрөгийн хүүгийн цэвэр ашигтай ажилласан. Хүүгийн орлого 2017 оныхоос 31.2 хувь, хүүгийн зарлага 42.9 хувь, хүүгийн цэвэр ашиг 17.7 хувиар өсжээ.

ЗУРАГ 20. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ



Хоршоодын тоо нь 2015 онд 253, 2016 онд 280, 2017 онд 290 байсан бол 2018 онд 279 болж өмнөх оноос 11 (3.8 хувь) буурчээ (Зураг20).

ДҮГНЭЛТ

Монгол банк үнийн өсөлтийг сааруулах, цаашид мөнгөний нийлүүлтээр түүнийг тэтгэхгүй байх, эрэлтийн гаралтай инфляцийн дарамтыг багасгаж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалах зорилгоор 2018 оны 3 дугаар сард мөнгөний бодлогыг чангаруулж, бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулан 10.0 хувьд хүргэсэн.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2017 онд өмнөх оноос 30.5 хувь өсөж байсан бол 2018 онд өмнөх оноос 22.8 хувиар буюу 7.7 пунктээр өсжээ. Бага мөнгө (M1) 2017 онд өмнөх оноос 31.6 хувь өсөж байсан бол 2018 онд өмнөх оноос 42.6 хувиар өссөн байна. Бараг мөнгө 2017 онд өмнөх оноос 30.2 хувь өсөж байсан бол 2018 онд өмнөх оноос 18.5 хувь өсөж, 11.7 пунктээр буурчээ.

Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийн цар хүрээ өргөжихийн хэрээр бага мөнгөнд банкнаас гадуурх мөнгөний эзлэх хувийн жин буурч, төгрөгийн харилцах голлох хувийг эзлэх болсон. Тухайлбал, төгрөгийн харилцахын бага мөнгөнд эзлэх хувийн жин 2018 онд 83.4 хувийг эзэлж, өмнөх оноос 5 пунктээр өссөн бол банкнаас гадуурх мөнгөний бага мөнгөнд эзлэх хувийн жин 2018 онд 16.6 хувь болж, өмнөх оноос 5.0 пунктээр буурсан байна.

Сүүлийн жилүүдэд төгрөгийн хадгаламжийн өсөлт илүү хурдацтай болж, валютын хадгаламжийн өсөлт саарч байгаа хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, төгрөгийн хадгаламж 2017 онд 2.8 их наяд төгрөгөөр буюу 48.9 хувиар, 2018 онд 1.5 их наяд төгрөгөөр буюу 17.8 хувиар өссөн байна. Гадаад валютын хадгаламж 2018 онд 19.3 хувиар өсөж, жилийн цэвэр өсөлт 28.6 пунктээр нэмэгджээ.

Банкны системийн дүнгээр 2018 онд нийт 22.1 их наяд төгрөгийн зээл олгосон нь өмнөх оноос 8.0 их наяд төгрөг буюу 55.8 хувиар, зээлийн эргэн төлөлт 18.3 их наяд төгрөг болж өмнөх оноос 5.9 их наяд төгрөг буюу 47.4 хувиар тус тус өсжээ. Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2018 оны эцэст 16.9 хувь болж өмнөх оноос 2.1 пунктээр, валютын зээлийн жигнэсэн дундаж хүү 8.8 хувь болж өмнөх оноос 2.8 пунктээр буурсан байна.

Төв банкны нэрлэсэн жилийн дундаж ханш 2018 онд ам.долларттай харьцах ханш 2472.67 болж өмнөх оноос 1.3 хувиар, евротой харьцах ханш 2918.78 болж өмнөх оноос 5.8 хувиар, юаньтай харьцах ханш 373.88 болж өмнөх оноос 3.5 хувиар суларч, рубльтэй харьцах ханш 39.49 болж өмнөх оноос 5.7 хувиар чангарсан байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны эцэст 17.2 их наяд төгрөг болж өмнөх оноос 3.6 их наяд төгрөг буюу 26.5 хувиар өсжээ. Зээлийн өрийн үлдэгдэлд хэвийн зээл 14.6 их наяд буюу 84.7 хувийг, хугацаа хэтэрсэн зээл 0.8 их наяд төгрөг буюу 4.9 хувийг, чанаргүй зээл 1.8 их наяд төгрөг буюу 10.4 хувийг тус тус эзэлж байна

Үнэт цаасны арилжаа 2018 онд нийт 252 өдөр явагдаж, 666.8 сая ш хувьцааг 210.0 тэрбум төгрөгөөр, 332.9 мянган ширхэг Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч захын

арилжааг 33.5 тэрбум төгрөгөөр, 6.3 мянган ширхэг компанийн бондыг 631.6 сая төгрөгөөр арилжиж, нийт 244.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО